

АНУ-ын үндэсний аюулгүй байдлын шинэ стратеги: агуулга, шинжилгээ

Пүрэвдоржийн Батжаргал

Доктор (Ph.D), төвийн дарга, batjargal@iss.gov.mn

Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн

Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Дэлхийн дэг журам, олон улсын аюулгүй байдлын тогтолцоо өөрчлөгдөн, цэрэг-улс төрийн байдал ээдрээтэй байгаа энэ цаг үед АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаа Үндэсний аюулгүй байдлын стратегиа (National Security Strategy) 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлан гаргасан нь олон улс, шинжээчдийн анхаарлын төвд байна. Тэд өөрсдийн бодлого, стратегитай харьцуулан үнэлгээ, шинжилгээ хийж байна.

Шинээр баталж, танилцуулсан баримт бичиг АНУ-ын дотоод нөхцөл байдал болон дэлхийн бүс нутгуудын аюулгүй байдлын өнөөгийн дүр зураг, цаашидын чиг хандлагад үнэлгээ өгсний зэрэгцээ тус улсын ашиг сонирхол, гадаад бодлого дунд хугацаанд хэрхэн, ямар чиглэлд илүүтэй анхаарал хандуулахыг тодорхойлсон агуулгатай байгаа юм. Хүйтэн дайнаас хойших АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын бүх стратегийг “юу хүсэж байгаа нь тодорхойгүй хүслийн жагсаалт байснаас үүдэн бүтэлгүйтсэн” хэмээн шинэ стратегид шүүмжилсэн явдал дотооддоо улс төр, нийгэм, эдийн засгийн асуудалд илүү төвлөрөх Д.Трампын засаг захиргааны бодлогын илэрхийлэл болж байна.

Түлхүүр үг: Дэлхийн дэг журам, дотоод нөхцөл байдал, бүс нутаг, эдийн засаг

Оршил

АНУ-ын засаг захиргаа бүр дэлхий дахины аюулгүй байдал болон дотоод нөхцөл байдалд цогц үнэлгээ хийсний үндсэн дээр бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэх аюулгүй байдлын бодлогыг тодорхойлсон үндсэн баримт бичиг болох “Үндэсний аюулгүй байдлын стратеги” (National Security Strategy)-г гаргадаг уламжлалтай. Дэлхийн геополитикийн чиг хандлагыг тодорхойлж ирсэн энэхүү баримт бичиг олон улсын харилцаа, аюулгүй байдлын орчинд өрнөх үйл явдлын дунд хугацааны дүр зургийг тодорхойлсон байдгаараа судлаач, шинжээчдийн анхаарлыг татдаг. Ялангуяа Д.Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр дахин сонгогдож, 2025 оны нэгдүгээр сарын 21-ний өдөр тангараг өргөсний дараахан өрнөсөн “Тарифын дайн”, Гренландыг худалдаж авах болон Канадыг Америкт нэгтгэх талаар хийсэн хурц мэдэгдлүүд, дэлхийн халуун цэгүүдэд өрнөсөн зөрчилдөөнийг зохицуулах хүчин чармайлт, Украины дайныг зогсоох чиглэлээр явуулж буй бодлого зэрэг нь түүний засаг захиргааны шинэ стратеги ямар байх бол гэсэн хүлээлт үүсгэж байв.

Шинэ стратегид орсон зарчмын өөрчлөлтүүд

Д.Трампын анхны бүрэн эрхийн хугацаанд батлагдсан ҮАБ-ын стратеги болон Үндэсний Батлан хамгаалах стратеги (National Defense Strategy) нь АНУ-ын гадаад бодлогын суурь баримжааг шинэ түвшинд гаргаж, БНХАУ, ОХУ-ыг их гүрний өрсөлдөөний гол тэнхлэг гэж тодорхойлсон бөгөөд тухайн үеийн гадаад бодлогын үндсэн тулгуур болж байсан. Хэдийгээр өмнөх стратеги хэрэгжилтийн хувьд төгс байгаагүй ч, АНУ-ын өмнө тулгарч байсан сорилтыг цогцоор нь тодорхойлж, тэдгээрийн эсрэг авах хариу арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх механизм, хамрах хүрээг тодорхой тогтоосон бодитой, нухацтай баримт бичиг байсан хэмээн үнэлэгддэг.

Шинэ стратегид¹ нэн тэргүүнд хүйтэн дайн дууссан 1990-ээд оноос хойш гарсан бодлогын баримт бичгүүдэд товч үнэлгээ өгсөн байна. Тэдгээрт тусгаснаар Америкийн гадаад бодлогыг тодорхойлогчид дэлхийн хэмжээний геополитик баримталж байсан нь үндэсний ашиг сонирхолд огт нийцэхгүй хүнд ачаа, хариуцлагыг үүрүүлж, улс орноо сулруулахад хүргэсэн хэмээн дүгнэжээ.

Д.Трампын засаг захиргаа нэгд, Америкийн ашиг сонирхол юунд чиглэх; хоёрт, хэрэгжүүлэх боломжит арга хэрэгсэл юу болох; гуравт, зорилго, арга хэрэгслээ ҮАБ-ын стратегид хэрхэн тусгах гэсэн асуудлаар судалгаа хийж, өөрсдийнх нь үзэж байгаагаар өмнөх алдааг залруулах зорилгоор үндэсний ашиг сонирхлоо хамгаалахад илүү анхаарсан чиглэлүүдийг тодорхойлжээ. Тухайлбал:

- Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг эрхэмлэж, иргэдийн эрх, ашиг сонирхол, сайн сайхан амьдралын төлөө байх үндсэн зарчмыг баримтлах;
- Үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөх бүх төрлийн аюулаас улс орон, ард түмнээ хамгаалах;
- Хилийн хяналт, цагаачлал, улс дамнасан тээврийн сүлжээний системийг бүхэлд нь хянахын зэрэгцээ иргэдийн шилжилт хөдөлгөөнийг дэг журамтай зохицуулахын төлөө бусад улстай хамтран ажиллах;
- Америкийн ард түмэн, эдийн засагт хор хөнөөл учруулж болзошгүй байгалийн гамшиг болон гадны аюул, заналхийллээс урьдчилан сэргийлж, сөрөн тэсвэрлэх чадвартай үндэсний дэд бүтцийг бэхжүүлэх;
- Ашиг сонирхлоо хамгаалах, шаардлагатай үед богино хугацаанд бага хохирлоор ялалтад хүргэх чадвартай, дэвшилтэт технологи бүхий дэлхийн хамгийн хүчирхэг зэвсэгт хүчинтэй байх;
- Америкийн иргэд, гадаадад байгаа хөрөнгө, холбоотнуудаа хамгаалах чадвартай дэлхийн хамгийн хүчирхэг, найдвартай, орчин үеийн цөмийн тогтоох барих хүчинтэй байх;
- Дэлхийн хамгийн хүчирхэг, шинэлэг, дэвшилтэт эдийн засагтай байх;
- Америкийн эдийн засгийн өсөлтийг бүрэн хангах чадвартайгаас гадна

¹ <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2025/12/2025-National-Security-Strategy.pdf>

экспортын тэргүүлэх салбар байх боломжтой эрчим хүчний хүчирхэг системтэй байх;

- Дэлхийн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх орны байр сууриа хадгалж, бэхжүүлэх;
- Америкийн үндэсний ашиг сонирхолд нийцсэн “зөөлөн хүчний бодлого” баримтлах;
- Эрүүл, ажилтай, орлоготой нийгмийг бүрдүүлж, дараагийн үедээ уламжлуулан үлдээх бодлого баримтлахаар тусгажээ.

Эндээс Трампын засаг захиргаа “Америк эн тэргүүнд” гэсэн үндэсний эрх ашгийг тэргүүлэх чиглэлд тавьсан бодлого баримтлах болсон нь илэрхий байна хэмээн дүгнэж болно.

Цагаан ордны баримтлах гадаад бодлогод зарчмын гэх зарим өөрчлөлт оржээ. Цагаачлал, терроризм, хар тамхины наймаа зэрэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээний байгууллагуудыг АНУ-ын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн хэмжээнд үнэлж, дэлхийн бөмбөрцгийн баруун хагас (Western Hemisphere)-ын тогтвортой байдлыг хангахад бүс нутгийн орнуудын хамтын ажиллагаа чухал болохыг онцолжээ. Америкийн гадаад бодлогод ийнхүү оршин буй бүс нутгийнхаа тогтвортой байдлыг тэргүүн зэрэгт тавьж байгаа нь бөмбөрцгийн баруун хагаст Хятадын аажмаар өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлахтай мөн холбоотой.

**Хүснэгт 1. 2022, 2025 оны Үндэсний аюулгүй байдлын стратегийн ялгаа
(харьцуулсан хүснэгт)**

Бодлого	2022 оны УАБ-ын стратеги	2025 оны УАБ-ын стратеги	Ялгаа
1	2	3	4
Стратегийн суурь үзэл баримтлал	Ардчилал, дүрэмд суурилсан олон улсын дэг журмыг хамгаалах, холбоотон төвтэй дэлхийн хэмжээний зохицуулалт	“Америк эн тэргүүнд” зарчим, дотоод аюулгүй байдал, дэлхийд хүчирхэг эдийн засагтай байх зорилтыг тэргүүнд тавьсан.	Дэлхийн дэг журам сахиулагч байр суурь суларч, өөрийн ашиг сонирхолд илүү төвлөрөх хандлагатай болсон .
Гол өрсөлдөгчийн тодорхойлолт	Хятад: Системийн өрсөлдөгч Орос: Шууд аюул	Хятад: Эдийн засгийн өрсөлдөгч Орос: Европын аюулгүй байдлын гол сорилт	Геополитикийн сөргөлдөөнөөс эдийн засгийн өрсөлдөөнд шилжиж, Москвад чиглэсэн хатуу бодлого суларсан.

Энэтхэг, Номхон далайн бүс нутаг	Стратегийн гол чиглэл	Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, эдийн засаг технологийн өрсөлдөөн	Аюулгүй байдлын ачааллыг холбоотнууддаа илүү үүрүүлэх
Тайваний асуудлаарх бодлого	Одоогийн байдлыг хадгалах, саатуулах ба мөргөлдөөнөөс сэргийлэх	Цэргийн давуу байдлаа хадгалах	Тайваний геостратегийн ач холбогдлыг нэмэгдүүлсэн.
Дэлхийн бөмбөрцгийн баруун хагас	Стратегийн хоёрдогч бүс нутаг	Стратегийн тэргүүлэх чиглэл болсон.	Америкийн гадаад бодлого Еврозиас бөмбөрцгийн баруун хагаст шилжих хандлагатай.
Европын бүс нутаг	НАТО, ЕХ гол түнш, хамтын аюулгүй байдлын тулгуур	Европын стратегийн ач холбогдол хэвээр, Европын дахин сэргэлтэд дэмжлэг үзүүлэх	Аюулгүй байдлын асуудлыг Европт илүү хариуцуулсан, Орос Европын сэргөлдөөнийг зохицуулах хандлагатай.
Орос, Украины дайн	Украинд дэмжлэг үзүүлэх нь тогтвортой зорилт	Украины дайныг зогсоох асуудлыг аль болох хурдан шийдвэрлэх	Америкийн ашиг сонирхолд нийцсэн, прагматик байдлаар хандах төлөвтэй.
Ойрх Дорнод	Стратегийн чухал ач холбогдолтой бүс нутаг	Бүс нутгийн газрын тос, байгалийн хийн нөөцөд өрсөлдөгч гүрнүүд хяналт тогтоохоос сэргийлэх	Бүс нутагт чиглэсэн идэвхтэй бодлого суларч болзошгүй ч ашиг сонирхол буураагүй.
Иран, Умард Солонгос	Хоёрдогч аюул, цөмийн хөтөлбөрт анхаарч байсан	Умард Солонгосыг дурдаагүй, Ираны аюулыг бууруулж үнэлсэн.	Цөмийн аюулын үнэлгээ бүдгэрсэн.
Африк	Либерал үзэл суртлыг дэлгэрүүлэх	Африкийн арвин байгалийн нөөц баялаг, далд эдийн засгийн чадавхыг ашиглах	Эдийн засгийн ашиг сонирхол нэмэгдсэн.

АНУ-ын 2022 оны ҮАБ-ын стратегид дэлхийн дэг журмыг хамгаалах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, ардчиллын үнэт зүйлсийг түгээх асуудлыг тэргүүн эгнээнд тавьж байсан бол шинэ стратеги “Америк эн тэргүүнд” зарчимд суурилан тусгаар тогтнол, хил хамгаалалт, эдийн засаг, технологийн давуу байдлаа хадгалахыг нэн тэргүүнд тавьж, цаашид дэлхийн бөмбөрцгийн баруун хагаст

Америкийн нөлөөллийг сэргээж, бэхжүүлэх зорилтыг тодорхой тусгажээ. Ингэснээр дэлхийн бөмбөрцгийн баруун хагасыг АНУ-ын геополитикийн нэн тэргүүний чиглэл хэмээн тодотгож, хууль бус цагаачлалын урсгалыг тогтоон барих, нарко-террорист бүлэглэлүүдтэй тэмцэх, Монрогийн номлол (Monroe Doctrine²)-ыг “Трампын нэмэлт зарчим” (Trump Corollary³)-аар өргөтгөн хэрэгжүүлэх замаар бүс нутаг дахь Америкийн нөлөө, ноёрхлыг бататгах зорилтыг агуулсан байна. Ийнхүү 2025 оны стратегид дэлхийн бөмбөрцгийн баруун хагас геополитикийн тэргүүлэх чиглэлд эрэмбэлэгдсэн нь 1987, 1990, 2006 онд батлагдсан стратегиудын дараа энэ бүс нутаг аюулгүй байдлын тэргүүлэх чиглэлээр дахин тодорхойлогдож буй тохиолдол болж байна. Энэ нь дараах үндэслэлтэй байна.

Бүс нутгийн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд Америкийн дотоод аюулгүй байдалд сүүлийн жилүүдэд эрсдэл, сорилт үүсгэж нийгмийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрээд байв. Нөгөө талаас, бөмбөрцгийн баруун хагасын орнуудын байгалийн баялагт хяналт тогтоож, энэ бүс нутгийг чиглэсэн Хятадын улс төр, эдийн засгийн нөлөөг хязгаарлах нь Америкийн хувьд аюулгүй байдлын тулгамдсан асуудлын нэг болсонтой холбоотой гэж болно. Хөрш орнууд нь улс төрийн үзэл баримтлал, засаглалын хэлбэрээрээ харилцан адилгүй байж болох ч, хэрэв АНУ-тай ашиг сонирхол нийлэх нөхцөл бүрдвэл үнэт зүйл ижил биш байсан ч хамтран ажиллах боломжтой түншүүд гэж тооцох хэрэгтэй гэж үзжээ. Өөрөөр хэлбэл: түншлэлд ардчилал, либерал үнэт зүйлсийг заавал урьдчилсан шалгуур болгон тавихгүй гэсэн байр суурь илэрхийлсэн байна.

Өмнөх стратегид Европын холбоо, НАТО-г гол түнш, хамтын аюулгүй байдлын тулгуур гэж тодорхойлж байсан бол 2025 оны стратегид Европ дахь уламжлалт холбоотнуудаа цагаачлалд хяналтаа алдсан, уугуул хүн амын өсөлт зогссон, соёл иргэншлийн хувьд суларсан, дахин сэргэх шаардлагатай хэмээн шүүмжилсэн. Учир нь Европт тулгамдсан гол асуудал нь “Барууны үнэт зүйлс” (үндсэрхэг, консерватив) суларч буй явдал бөгөөд үүний шалтгаан нь цагаачлалаас үүдэлтэй үндэсний ондоошил алдагдаж, хүн амын төрөлт огцом буурч буй байдал гэж үзжээ. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт удааширч, батлан хамгаалах чадавх сулрах, улмаар Европ “иргэншлийн хувьд сулрах” аюултай нүүр тулж байна гэж стратегид дүгнэсэн байна.

Стратегид Хятадтай хийж буй худалдааны алдагдлын хэт өсөлт, технологийн хулгайтай тэмцэх чиглэлд Европтой бодлогын түвшний уялдаа чухал болохыг

² “Monroe Doctrine” нь АНУ-ын гадаад бодлогын түүхэн үндэс баримт бичиг бөгөөд 1823 онд Ерөнхийлөгч Жеймс Монро Конгресст тавьсан илтгэлдээ анх дурдсан. Энэхүү номлол нь АНУ-ыг Америк тив дэх стратегийн давамгайлалч хүчин гэсэн үндсэн зарчмыг тодорхойлж, XIX-XX зуунд Америкийн геополитикийн бодлогын гол тулгуур болон хэрэгжсэн юм. Өөрөөр хэлбэл: Европын улс төрийн оролцоо болон шинэ колоничлолын нөлөөллийг Америк тивд хүлээн зөвшөөрөхгүй байх, харин бүс нутгийн дотоод бодлого, аюулгүй байдал, стратегийн тэнцвэрийг АНУ онцгой эрхтэйгээр хянах зарчимд суурилсан баримт бичиг гэж тодорхойлж болно.

³ “Trump Corollary”: АНУ-ын УАБ-ын стратегид тусгагдсан шинэ бодлогын хүрээ юм. Энэ нь АНУ Америк тивийг өөрийн үндсэн нөлөөллийн бүс гэж үзэж, гаднын улсуудын (ялангуяа БНХАУ, ОХУ) оролцоог хязгаарлах зорилготой.

тэмдэглэсэн байна. Гэвч Европын орнуудын стратегийн ач холбогдлыг жигд бус байдлаар үнэлж, Төв, Зүүн болон Өмнөд Европын орнуудыг “Эрүүл улс” гэж онцолж, тэдэнтэй харилцааг өргөжүүлэхийг илүү дэмжсэн байна. Харин Баруун Европын уламжлалт холбоотнуудаа “Сул дорой” улсууд хэмээн үнэлсэн нь дээр дурдсан цагаачлал, соёл иргэншлийн тулгамдсан асуудлуудтай холбоотой.

Шинэ стратегид НАТО-г тэлэх “Нээлттэй хаалганы бодлого” (open-door policy)-ыг дэмжихгүй гэсэн байр суурь илэрхийлж, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг өөрсдөд нь хариуцуулах болсон нь трансатлантикийн аюулгүй байдлын тогтолцоонд эргэлзээ үүсгээд байна. Америкийн зүгээс Европын геостратегийн ач холбогдол хэвээр байгааг дурдаад, дахин сэргэлтэд дэмжлэг үзүүлж, тэдэнтэй асуудлаа бие даан шийдвэрлэхэд нь хамтарч ажиллахаа илэрхийлж байна. Мөн Европын орнуудыг Украины асуудлаар “энх тайвны төлөө хүчин чармайлт гаргаагүй”, “бодит бус, хэт дэврүүлсэн төсөөлөл”-ийг бий болгосон хэмээн тодорхойлсон нь бүс нутгийн аюулгүй байдлын талаарх үнэлгээ хол зөрүүтэй байгааг харуулав.

ҮАБ-ын стратегид Украины дайныг зогсоох асуудлыг аль болох хурдан шийдвэрлэх талаар дурдсан ч хэрхэн гэдэг талаар тодорхой байр суурь илэрхийлээгүй нь АНУ-ын ашиг сонирхлын хүрээнд прагматик байдлаар шийдвэрлэх байр суурь баримталж буйтай холбоотой байна. Орос, Украины хямралын асуудлаар энэ стратегид Америк, Оросын харилцааг тэргүүнд тавьж, стратегийн тогтвортой байдал, Европ дахь хурцадмал байдлыг удирдах, сэргөлдөөн даамжрахаас сэргийлэх асуудлыг хөнджээ. Мөн Украин “амьдрах чадвартай, бүрэн оршин тогтнох улс хэвээр үлдэх шаардлагатай” гэж тодорхойлж, сэргээн босголтыг дэмжихээ илэрхийлсэн ч энэ зорилгод хэрхэн хүрэх арга замыг тодорхой заагаагүй байна.

Шинэ стратегид ОХУ-ыг урьдын адил “шууд аюул”, “өрсөлдөгч” гэж нэрлэлгүй “... Европын олон улс Оросыг оршин тогтнолдоо заналхийлсэн үндсэн аюул гэж үздэг...” хэмээн дам байдлаар томьёолсон нь Москвагийн хувьд хоёр орны хурцадмал харилцаа зогсож, улмаар сайжрах дохио гэж харах үндэстэй болов. Дээр дурдсанчлан НАТО-г тэлэх бодлогыг дэмжихгүй гэсэн байр суурь илэрхийлсэн нь Кремлийн ашиг сонирхолд бүрэн нийцэж байгаа нь тодорхой.

Ерөнхийлөгч Д.Трампын анхны засаглалын үед батлагдсан ҮАБ-ын стратеги БНХАУ-тай их гүрний өрсөлдөөний шинэ үеийг эхлүүлсэн гэж үздэг. Уг баримт бичигт БНХАУ-ыг АНУ-ын үнэт зүйлс болон ашиг сонирхолд харш, дэлхийн дэг журмыг өөрийн ашигт нийцүүлэн дахин төлөвшүүлэхийг зорьсон хэмээн тодорхойлж байв.

ҮАБ-ын өмнөх стратегиудад БНХАУ-ыг стратегийн өрсөлдөгчийн түвшинд үнэлж байсан тул АНУ-ын геополитикт Ази тив тэргүүлэх байр суурь эзэлж байв. ҮАБ-ын шинэ стратегид АНУ болон түүний холбоотнуудад БНХАУ-аас учруулж буй сорилтыг эдийн засгийн талаас нь үнэлж, “... эдийн засгийг жинхэнэ өрсөлдөөний талбар ...” хэмээн дурдаж, Вашингтоны Бээжинтэй харилцах бодлогын гол зорилго нь “...

Бээжинтэй эдийн засгийн харилцан ашигтай тэнцвэртэй харилцааг тогтоох...” гэж тодорхойлжээ. Бээжингийн хувьд хоёр улсын өрсөлдөөн геополитикийн талбараас эдийн засгийн чиглэлд шилжсэн нь Вашингтоны хатуу бодлого суларч, харилцаа дулаарах боломж үүсгэнэ гэсэн өнцгөөр харж болох юм. Учир нь 2025 оны УАБ-ын стратегид хоёр орны хооронд “харилцан ашигтай эдийн засгийн харилцаа” хөгжүүлэх боломж нээлттэй гэдгийг илүү тод илэрхийлжээ. Ингэснээр эдийн засгийн тэнцвэртэй харилцааг нэгдүгээр зорилт болгож, геополитикийн өрсөлдөөний ач холбогдлыг бууруулсан байна. Гэвч Америк-Хятадын их гүрний өрсөлдөөн дуусгавар болсон гэж дүгнэж болохгүй юм.

АНУ Тайваньд аюулгүй байдлын баталгаа өгөөгүй боловч (өгөх ч боломжгүй) геостратегийн ач холбогдлыг нь өмнөхөөс өндөр тавьсан нь анхаарал татаж байна. Үүнээс үүдэн арлыг тойрсон сөргөлдөөн дунд хугацаанд хурцадмал хэвээр байх төлөвтэй байна. Шинэ стратегид Тайванийн газар зүйн онцгой байрлал Америкийн хувьд геостратегийн чухал ач холбогдолтой гэдгийг тэмдэглэсэн байна. Стратегид Тайванийн арал руу чиглэсэн БНХАУ-ын цэргийн түрэмгийллийг саатуулах асуудлыг тодотгон, ялангуяа нэгдүгээр арлын гинжин бүсэд хүч хэрэглэх замаар зэвсэгт мөргөлдөөнийг няцаахуйц цэргийн хүч хадгалах шаардлагатайг онцолсон. *“Тайванийн хоолойд зэвсэгт мөргөлдөөн үүсэхээс сэргийлэх нь тэргүүний зорилт бөгөөд үүнийг цэргийн давуу байдлыг хадгалах замаар хэрэгжүүлэх нь оновчтой”* гэсэн нь байдал хурцадвал Тайпайд цэргийн тусламж үзүүлэх агуулгатай гэж үзэж болохоор байна.

Энэтхэг-Номхон далайн бүс нутагт чиглэсэн бодлогын тухайд 2022 оны УАБ-ын стратеги Хятадтай өрсөлдөх манлайллыг Америк өөртөө хадгалж байсан бол 2025 оны стратегид зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх асуудлыг урьтал болгохын зэрэгцээ Япон, Өмнөд Солонгос, Австрали, Тайвань зэрэг бүс нутгийн түншүүдийнхээ аюулгүй байдлын хариуцлагыг нэмэгдүүлэх хандлага тусгагдсан байна. Энэтхэг-Номхон далайн бүс нутагт чиглэсэн Америкийн бодлого цаашид Хятад төвтэй хэвээр байх бөгөөд уг стратегид Номхон далайн баруун бүсэд илүү анхаарал хандуулж, батлан хамгаалах гэрээний холбоотон Филиппин, Номхон далайн арлууд болон Зүүн Өмнөд Азийн олон улс огт дурдагдаагүй нь ашиг сонирхол хаашаа чиглэж байгаатай холбоотой.

УАБ-ын стратегид (2017) Иран, Умард Солонгосыг II түвшний аюул хэмээж байсан бол шинэ стратегид Умард Солонгосыг дурдалгүй, харин “Midnight Hammer” ажиллагааны дараа Ираны аюул, заналыг мэдэгдэхүйц бууруулсан хэмээн үнэлжээ.

Шинэ стратегид уур амьсгалын бодлогыг шүүмжилж, газрын тос, хий, нүүрс, цөмийн эрчим хүчийг сэргээн дэмжихийн зэрэгцээ эдийн засгийг дахин нутагшуулах, ханган нийлүүлэлтийн сүлжээг АНУ-д төвлөрүүлэх зорилт тавьжээ.

Стратегийн хэрэгжилтэд түнш орнуудыг татан оролцуулах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, нөөц, үйлдвэрлэлийг

хөгжүүлэх, АНУ-ын бараа бүтээгдэхүүн импортлох, Америкийн хувийн хөрөнгө оруулалтын урсгалыг бүс нутаг руу чиглүүлэх, бизнесүүдийн оролцоог нэмэгдүүлэх, түүнчлэн “гадаадын дайсагнасан нөлөө”-г саармагжуулахад оролцуулах шаардлагатай гэж үзжээ. Үүнийг хэрэгжүүлэхдээ санхүүгийн дэмжлэг, дипломат шахалт үзүүлэх, “урамшууллын механизм” зэрэг арга хэрэгслийг ашиглах боломжтой хэмээн стратегид тусгасан байна.

Дүгнэлт

Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргаанаас хоёр дахь бүрэн эрхийнхээ хүрээнд гаргаж буй УАБ-ын стратеги нь анхны бүрэн эрхийн хугацаанд боловсруулсан стратегитай харьцуулахад агуулга болон шинж чанарын хувьд мэдэгдэхүйц өөрчлөгдсөн байна. Дэлхий дахины аюулгүй байдлын өргөн асуудалд хэт оролцоотой байсан бодлогыг “алдаа” байсан хэмээн үзэж, хүйтэн дайнаас хойш хуримтлагдсан бодлогын эдгээр алдаанд бодитой “тохируулга” хийж, стратегийн шинэ чиглэл тодорхойлсон баримт бичиг болсноороо онцлогтой аж. Ийнхүү АНУ-ын бодлого их гүрнүүдийн геополитикийн шууд сөргөлдөөнөөс зайлсхийж, эдийн засаг, бүс нутгийн ачааллын дахин хуваарилалт руу шилжиж байгаа нь олон улсын аюулгүй байдал, эдийн засгийн харилцаа дунд хугацаанд тогтвортой байх найдлагыг төрүүлж байгаа юм.

ОХУ, БНХАУ уг стратегийг харьцангуй прагматик, өмнөхтэй харьцуулахад аядуу байдлыг эрэлхийлсэн хэмээн үзэж хүлээн авч байгаа нь дэлхийн геополитикийг тодорхойлогч их гүрнүүдийн харилцаа дунд хугацаандаа айхтар хурцдахгүй тэнцвэртэй байх гэсэн төлөвийг бий болгож байна. Харин Европын Холбоо болон түүний гол гишүүн орнуудын хувьд энэхүү стратеги нь трансатлантикийн харилцааг сулруулах, Европ өөрөө аюулгүй байдлын илүү их хариуцлага үүрэх шаардлагатай болж буй дохио хэмээн болгоомжлон хүлээж авч байгаа ч англосаксоны уламжлалт нэгдмэл ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхгүй.

Америк стратегийн тэргүүлэх чиглэлээ Энэтхэг, Номхон далайгаас дэлхийн бөмбөрцгийн баруун хагаст шилжүүлж, гадаад бодлогын манлайллаас илүүтэй үндэсний ашиг сонирхол, дотоод аюулгүй байдал, эдийн засгийн давуу байдлыг чухалчлах болсон нь бусад улс орнуудын хувьд Вашингтоны оролцоо багасах, харин өөрсдийнх нь хариуцлага нэмэгдэх бодит нөхцөлийг бий болгож байна. Энэ нь холбоотнууд болон түнш орнуудад өөрсдийн стратегийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, шинэ тэнцвэр хайх шаардлагыг бий болгожээ.

Монгол Улсын тухайд энэхүү стратегийн хэрэгжилт боломж, эрсдэлийг зэрэгцүүлсэн орчныг бүрдүүлнэ. Нэг талаас АНУ–БНХАУ, АНУ–ОХУ-ын харилцаан дахь шууд хурцадмал байдал буурч болох хандлага нь Монгол Улсын гадаад бодлогын маневрын орон зайг богино болон дунд хугацаанд хадгалах боломж олгож байна. Нөгөө талаас АНУ-ын бүс нутгийн оролцоо буурах, “харилцан ашигтай байх” зарчим давамгайлах нь Монголын “гуравдагч хөрш”-ийн бодлого, аюулгүй байдлын тэнцвэрт байдалд шинэ сорилт үүсгэж болзошгүй.

The U.S. National Security Strategy: Content and Analysis

Batjargal Purevdorj

Doctor Ph.D, Head of Center, batjargal@iss.gov.mn

The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

In the context of a transforming world order, an evolving international security architecture, and an increasingly tense military-political environment, the Trump-2.0 administration's adoption of a new National Security Strategy (NSS) on December 4, 2025, has garnered significant attention from security experts, national leaders, and policymakers across various regions. Many are now comparing their own policies and strategic priorities with this document while assessing its implications and anticipating future trends.

The strategy evaluates both the United States' domestic security environment and the broader global security landscape, outlines anticipated future developments, and identifies the medium-term priorities shaping U.S. national interests and foreign-policy orientation. Notably, the document sharply criticizes all post-Cold War U.S. National Security Strategies as "a list of vague aspirations that ultimately failed," arguing that they have weakened America's global dominance. In contrast, the Trump-2.0 NSS signals a strategic reorientation away from expansive global commitments toward a stronger emphasis on domestic political, social, and economic consolidation.

Keywords: *World order, domestic environment, regional security, economy, national strategy*

Received: December 3, 2025 | Accepted: December 24, 2025 | Published online: December 30, 2025



© The Author(s) 2025

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.